



**“БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 04 дугаар сарын 30 өдөр

дугаар 01

Улаанбаатар хот

“Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн 14 цаг 15 минутанд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Тайваны төвийн 207 тоот өрөөнд эхлэв.

Хуралд 225.323 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч А.Ариун-Эрдэнэ, “Силк Рөуд Сервисес ” ХХК-ыг төлөөлөн Эльер Хасанов мөн “Мезза Файнэншл Групп” ХХК –ийн гүйцэтгэх захирал Камолиддин Талипов нарын 3 хувьцаа эзэмшигчид онлайнаар оролцсон бөгөөд энэ нь нийт саналын 84 хувь болж байгааг хурал зохион байгуулах комиссын дарга А.Ариунтуяа тооллогын комиссын дарга Ц.Батболд нар мэдэгдэж, хурал хүчин төгөлдөрт тооцох тухай тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулснаар хурал эхлэв.

Хурлын дарга А.Ариунтуяа эхлээд хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд :

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах.
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай
5. Бусад

Хурлын дарга А.Ариунтуяа:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 2021 онд бид ард иргэдийн үнэт цаасны дансыг нээж , компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх үүднээс албан байгууллага сургуулиудаар явж үнэт цаасны зах зээлийн талаар болон компанийнхаа сурталчилгааг үнэ төлбөргүй хийсэн.

2019 онд “ Эрдэнэс Таван Толгой ” ХК ашигтай ажилласан тул ноогдол ашиг тараах тухай мэдээлэл цацагдаж ард иргэдийн идэвхи, санаачилга нэмэгдсэн мөн үнэт цаасны компанийн үйл ажиллагаа сайн явагдсан.

Компанийн хувьд зохицуулалттай хуулийн этгээд учир үндсэн үйл ажиллагаанаас өөр төрлийн бизнес эрхлэх хориотой байдаг иймд бид үйл ажиллагаагаа илүү өргөжүүлэх үүднээс харилцагч олонтой болохын төлөө ажиллаж байна. Та бүхэн имэйлээр явуулсан санхүүгийн тайлантай танилцсан гэж бодож байна. Мөн одоо асуух зүйл байвал асуугаарай.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй

Хурлын дарга А.Ариунтуяа : Хэлэлцэх асуудлын дараагийн зүйл Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулж хэлэлцье гэв.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж батлав.

Хурлын дарга А.Ариунтуяа : Компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч ашигтай ажиллаж чадахгүй байгаа учир ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 16 –ны өдрийн № 01 тоот тогтоолыг хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангах болон нэмж үйл ажиллагааны чиглэлд хөрөнгө оруулалтын зөвлөхийн эрх авах тухай танилцуулав.

Хувьцаа эзэмшигч Меза Файнэншил Группийн төлөөлөл Камолиддин Талипов : Миний хувьд энэ компанид хөрөнгө оруулалт олон жил хийж байгаа боловч ашиг гэх юм ерөөсөө харагдахгүй байна. Тиймд хөрөнгө оруулалтын зөвлөхийн эрх аван ажиллах нь зөв гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд санал нэгтэй зөвшөөрч, бид энэ эрхийг нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхэд хамааруулан үлдээж байна гэв.

Хурлын дарга А.Ариунтуяа : Дараагийн асуудал бусад гэх асуудлын хрээнд “Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох” тухай хэлэлцье. Төлөөлөн Удирдах Зөвлөлд одоо байгаа гишүүдийн танилцуулгыг та бүхэнд харуулж байна. Та бүхэн шинэ гишүүдийн анкет болон товч танилцуулгаас харна уу.

Хурлын дарга А.Ариунтуяа: –Гишүүдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгоход санал нэг байгаа нь саналын хуудсан дээрээ бичээрэй.

Хувьцаа эзэмшигчид: Татгалзах зүйлгүй. Дэмжиж байна.

Хурлын дарга А.Ариунтуяа : Таны хэлсэн зүйлийг ойлголоо. Та бүхэнд хурлаар хэлэлцэгдсэн асуудлаас гадна хэлэх санал, хүсэлт байна уу?

Хувьцаа эзэмшигчид – Нэмж хэлэх зүйл алга гэв.

Хурлын дарга А.Ариунтуяа : – За тэгвэл бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дуусч байна. Ингээд санал хураалтаа эхлүүлье.

Хувьцаа эзэмшигч Меза Файнэншил Группийн төлөөлөл Камолиддин Талипов : Компани өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооны шаардлагыг биелүүлэх, эрхээ сэргээлгэх шаардлагатай байгаа. Энэ асуудлыг нэмэлт хувьцаа гаргаж шийдвэрлүүлэх саналтай байна.

Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсөний дараа хурлын дарга Хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож, нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна. Хүчингүй саналын хуудас гараагүй.

“ Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК-ийн 2021 оны 4 дүгээр сарын 30 -ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэж хангалттай гэж дүгнэлээ.
2. Компанийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хурлаар хэлэлцэгдсэнээр баталж, холбогдох төсөл боловсруулахыг даалгав.
3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөв.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай тайлагнав.
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгов.
6. Бусад

Хурлын дарга А.Ариунтуяа :— Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд амжилт хүсье. Баярлалаа.

“ Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 15 цаг 40 минутад дуусав.

Хурлын даргалагч :

“Блюскай Секьюритиз ҮЦК ” ХК –ийн

Гүйцэтгэх Захирал

А.Ариунтуяа

Тэмдэглэл хөтөлсөн:

Л.Дөлгөөн

